



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЭНХБОЛД
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.04.21 № 17

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна” хэмээн тусгасан байдаг.

Энэ хүрээнд Улсын Их Хурал Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай зэрэг холбогдох хуулиудыг шинэчлэн баталж иргэд хүссэн эмнэлгээрээ үйлчлүүлэх, өндөр өртөгтэй мэс заслыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч дээрх хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар иргэдийн санал гомдол их байна.

Мөн Азийн хөгжлийн банкны 13 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр Ховд аймаг дахь Баруун бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өргөтгөлийг барих, тоног төхөөрөмжөөр хангах, эмч ажилтнуудыг сургаж мэргэшүүлэх ажлын явц байдлын талаар тодорхой мэдээллийг олон нийтэд хүргэх шаардлагатай байна.

Түүнчлэн коронавирусын цар тахлын халдвар өдрөөс өдөрт нэмэгдэж буй ч халдвараас хамгаалах гол арга хэрэгсэл болсон вакцинжуулалт Ховд зэрэг зарим аймагт нэн удаашралтай байгааг яаралтай эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дугаар зүйлийн 39.1.1-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дээрх хуулийн хэрэгжилт болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах асуулгыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд Танд хандан тавьж байна.

Үүнд;

1. УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэн баталсан Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Хөнгөлөлттэй эмийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах чиглэлээр Эрүүл мэндийн яам хэрхэн ажиллаж байгаа талаар;
2. Иргэд эмнэлгээ өөрөө сонгож үйлчлүүлэх, бүх төрлийн хавдар, өндөр зардалтай хагалгаа, хүүхдийн өндөр өртөгтэй мэс заслыг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь санхүүжүүлэх хуулийн заалт хэрхэн хэрэгжиж, одоогийн байдлаар хэчнээн иргэн хамрагдаад байгаа талаар;

2020000159